



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/239

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.10 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн төлөвлөлт, үр дүн, гүйцэтгэлийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж дүгнэлт гаргах, санал боловсруулах, чиг үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч : Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд:

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга Эрүүл мэндийн газрын Мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Санхүү, хөрөнгө оруулалт, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

2. Эрүүл мэндийн байгууллагуудын 2020, 2021, 2022 оны нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн дүн, гүйцэтгэл, гарсан үр дүн, 2023 оны төлөвлөлттэй холбоотой баримтуудыг нягтлан судалж, дүгнэлт гарган, санал боловсруулж аймгийн Засаг даргад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн гишүүд болон ажлын хэсгийн ахлагч Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүн)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710010101009